



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/010/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 260512 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn Ахлах аудитор:П.Амарсанаа Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:Аккаунт траст аудит ХХК-ийн захирал П.Наранцэцэг Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



БАГАНУУР ТООСГО ТӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ, ХОШУУЧ Б.ПҮРЭВДОРЖ  
ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.24 № 07/1161  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны борлуулалтын орлогын төлөвлөгөөг 73.4 сая төгрөгөөр буюу 21.7 хувиар тасалсан зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3- т “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус үйлдвэрийн газар тайлант онд үндсэн үйлдвэрлэлээс 261.6 сая төгрөг, бусад орлого 3.4 сая төгрөг, нийт 265.0 сая төгрөгийн орлого олж, нийт 422.6 сая төгрөгийн зардал гарч, үйл ажиллагаанаас 157.6 сая төгрөгийн алдагдалтай, ШШГЕГ-т 12.5 сая төгрөг төвлөрүүлснээр нийт 170.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

## Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Зах зээлд тус үйлдвэрийн газрын үндсэн бүтээгдэхүүн болох тоосгоны эрэлт хэрэгцээ буурсан тул шинээр 5 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн ч хөрөнгө санхүүжилтийн эх үүсвэргүйгээс томоохон өөрчлөлт шинэчлэлт хийж чадаагүй байна.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АУОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	2023оны 12-р сарын 31	2024оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4,370,594.09	1,593,666.24
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	949,827.27
1.1.4	Бусад авлага	27,642,850.50	14,358,500.00
1.1.6	Бараа материал	148,937,102.30	90,068,876.39
1.1.20	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>180,950,546.89</b>	<b>106,970,869.90</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	180,543,809.41	133,641,840.20
1.2.2	Биет бус хөрөнгө	21,794.98	2,477,916.65
1.2.20	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>180,565,604.39</b>	<b>136,119,756.85</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>361,516,151.28</b>	<b>243,090,626.75</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1.1	Дансны өглөг	-	45,631,200.00
2.1.1.3	Татварын өр	8,532,918.26	14,539,416.72
2.1.1.20	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>8,532,918.26</b>	<b>60,170,616.72</b>
2.1.2.20	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>8,532,918.26</b>	<b>60,170,616.72</b>
2.3.1	Төрийн өмч	192,291,669.83	192,291,669.83
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	213,578,963.04	213,578,963.04
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(52,887,399.85)	(222,950,622.84)
2.3.20	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>352,983,233.02</b>	<b>182,920,010.03</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>361,516,151.28</b>	<b>243,090,626.75</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого ( цэвэр )	171,310,064.92	261,629,620.00
3	Борлуулалтын өртөг	92,291,669.19	212,961,293.77
<b>4</b>	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>79,018,395.73</b>	<b>48,668,326.23</b>
11	Ерөнхий ба удирдлагын зардал	125,678,974.11	209,654,797.82
18	Бусад ашиг ( алдагдал )	35,000.00	3,423,248.60
19	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>(46,625,578.38)</b>	<b>(157,563,222.99)</b>
20	Орлогын татварын зардал	-	-
21	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>(46,625,578.38)</b>	<b>(157,563,222.99)</b>
22	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	-	-
23	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>(46,625,578.38)</b>	<b>(157,563,222.99)</b>
28	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(46,625,578.38)</b>	<b>(157,563,222.99)</b>
29	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>	15,000,000.00	12,500,000.00

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	192,291,669.83	117,668,893.04	8,738,178.53	318,698,741.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	95,910,070.00	-	95,910,070.00
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	192,291,669.83	213,578,963.04	8,738,178.53	414,608,811.40
4	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	(46,625,578.38)	(46,625,578.38)
7	Зарласан ногдол ашиг	-	-	(15,000,000.00)	(15,000,000.00)
9	<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	192,291,669.83	213,578,963.04	(52,887,399.85)	352,983,233.02
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	192,291,669.83	213,578,963.04	(52,887,399.85)	352,983,233.02
12	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	(157,563,222.99)	(157,563,222.99)
15	Зарласан ногдол ашиг	-	-	(12,500,000.00)	(12,500,000.00)
	<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	192,291,669.83	213,578,963.04	(222,950,622.84)	182,920,010.03

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>215,562,450.00</b>	<b>280,577,910.50</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	210,857,450.00	210,480,560.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	4,705,000.00	70,097,350.50
<b>1.20</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>200,001,372.57</b>	<b>269,154,838.35</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	100,988,002.39	138,509,932.88
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,418,315.23	2,864,516.51
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	37,572,100.00	72,782,550.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	7,197,500.00	2,175,000.00
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	26,536,300.00	21,939,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,421,268.83	19,702,498.60
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	617,850.00	563,850.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	21,250,036.12	10,617,490.36
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>15,561,077.43</b>	<b>11,423,072.15</b>
<b>2.00</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	<b>1,700,000.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		1,700,000.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>(1,700,000.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>15,000,000.00</b>	<b>12,500,000.00</b>
3.2.4	Төлсөн ногдол ашиг	15,000,000.00	12,500,000.00
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(15,000,000.00)</b>	<b>(12,500,000.00)</b>
5.00	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<b>561,077.43</b>	<b>(2,776,927.85)</b>
6.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,809,516.66	4,370,594.09
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,370,594.09	1,593,666.24

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөүү	Биел элт хувь
			Тоо	Бүгд	Тоо	Бүгд		
1	Үйлдвэрлэл							
1.1	Тоосго	мян/шир	400.0	120,000.0	312.4	76,535.8	43,464.2	63.8
1.2	Полистрол/хөнгөн блок 60x36x24/	м3	250.0	62,500.0	313.0	59,800.0	2,700.0	95.7
1.3	Евро хашаа	мян/шир	1100	55,000.0	1746	63,545.0	(8,545.0)	115.5
1.4	Нүхтэй блок	мян/шир	10.0	21,000.0	11.4	22,325.5	(1,325.5)	106.3
1.5	Төмс хүнсний ногоо	тн	100.0	80,000.0	63.3	41,373.7	38,626.3	51.7
1.6	Бусад орлого	мян.төг	-	-	-	1,472.9	(1,472.9)	-
1	<b>Нийт орлогын дүн</b>	<b>мян.төг</b>	<b>-</b>	<b>338,500.0</b>	<b>-</b>	<b>265,052.9</b>	<b>73,447.1</b>	<b>78.3</b>
2.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	-	-	-	212,961.29	(212,961.3)	-
2.2	Ерөнхий удирдлагын зардал	мян.төг	-	-	-	209,654.80	(209,654.8)	-
3	<b>Нийт зарлагын дүн</b>	<b>мян.төг</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>422,616.09</b>	<b>(422,616.1)</b>	<b>-</b>
	<b>Татварын өмнөх ашиг алдагдал</b>	<b>мян.төг</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>(157,563.19)</b>	<b>157,563.2</b>	<b>-</b>
	Орлогын татвар	мян.төг	-	-	-	-	-	-
	<b>Цэвэр ашиг алдагдал</b>	<b>мян.төг</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
5	<b>Төрийн өмчийн ноогдол ашиг</b>	<b>мян.төг</b>	<b>-</b>	<b>25,000.0</b>	<b>-</b>	<b>12,500.0</b>	<b>12,500.0</b>	<b>50.0</b>
	<b>Төсөвт төлөх татвар, шимтгэл</b>	<b>мян.төг</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>39,759.00</b>	<b>-</b>	<b>-</b>
	НӨАТ	мян.төг	-	-	-	20,523.90	-	-
	ХХОАТатвар	мян.төг	-	-	-	13,506.10	-	-
	Нийгмийн даатгалын шимтгэл	мян.төг	-	-	-	5,729.00	-	-
8	Батлагдсан ажилтны тоо		-	-	6	6	-	-
10	Нийт цалингийн сан	мян.төг	-	94,121.20	-	147,007.40	-	-
11	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	-	15,686.87	-	24,501.23	-	-
14	Нийт авлага	мян.төг	-	-	-	15,308.33	-	-
15	Нийт өглөг	мян.төг	-	-	-	60,170.62	-	-

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

3.1. Аудитаар тайлант оны борлуулалтын орлогын төлөвлөгөө 73.4 сая төгрөгөөр буюу 21.7 хувиар тасалсан 1 зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлээ.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус үйлдвэрийн газар нь тайлант оны борлуулалтын орлогын төлөвлөгөөг 73.4 сая төгрөгөөр буюу 21.7 хувиар тасалсан, үйл ажиллагаанаас 157.6 сая төгрөгийн алдагдалтай, ШШГЕГ-т 12.5 сая төгрөг төвлөрүүлснээр нийт 170.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	1	73,447.1	-	-	1	73,447.1	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>73,447.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>73,447.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>